

МЭРГЭШЛИЙН ХҮРЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?**Гэлэгийн Цагаач, доктор (PhD), МУИС-ШУС-ийн Эдийн засгийн тэнхим, дэд профессор****Хураангуй**

Боловсрол, сургалтын үйл ажиллагааны “чанар” тааруу байгаа талаар, бэлтгэн гаргаж буй бүтээгдэхүүн нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд төдийлөн нийцэхгүй байгаа талаар Монгол Улсад сүүлийн хэдэн жилд бүх шатанд ярьж, хэлэлцсээр ирлээ. Тэгвэл, энэ асуудал зөвхөн манай улсын хувьд сорилт болж буй бус, олон улсын хувьд нийтлэг тулгамдаж буй асуудалд тооцогдсоор ирснийг дэлхий даяарх 1980-аад оноос хойшх боловсрол, сургалтын үйл ажиллагааны явц, үр дүн, шинэчлэлийн ерөнхий чиг хандлага харуулж байна. Боловсролын салбар дахь өөрчлөлт, шинэчлэлт нь “*ори, үйл явцыг чухалчилсан тогтолцоо*”-ноос “*үр дүн, чадамжийг чухалчилсан тогтолцоо*”-нд шилжих чиглэлд буй бөгөөд мэргэшлийн хүрээ (qualifications framework)-г салбар, улс, бүс нутгийн хэмжээнд бүрдүүлж, үр дүнд суурилсан тогтолцооны “*малгай*” хэлбэрээр хэрэглэх нь түгээмэл байна. Өөрчлөлт, шинэчлэлтийн энэхүү давалгаа Монгол Улсыг ч тойрсонгүй, үр дүнд суурилсан тогтолцоог боловсролын чанарыг сайжруулах үндсэн арга болгох, энэ хүрээнд Үндэсний мэргэшлийн хүрээ (National Qualifications Framework)-г бий болгох ажлыг хийж байна. Аливаа арга хэмжээний үр дүнтэй хэрэгжилт нийтээрээ уг арга хэмжээний талаар нэгдсэн ойлголттой болж чадсан эсэхээс ихээхэн хамаардаг тул үүнд багахан хувь нэмэр оруулах зорилгоор энэ өгүүлэлд мэргэшлийн хүрээ гэж юу болох, түүний бүтэц бүрэлдэхүүн, Монгол Улсын хувьд ямар загвартай байж болох талаар товч өгүүлэв.

Abstract

The issues of poor quality education and teaching practice and the failure of graduates to respond to market needs have been central to dialogues at all levels in Mongolia. However, many countries around the world are actively engaged in reforming their education and training system in compliance with their socio-economic development and reform tendency. According to the approach of education reform, it is converting from input and process based system to outcome and competence based system. The development of a National Qualifications Framework has been a major international trend in reforming national education and training systems since the 1980s. Mongolia is one of those countries undergoing reform in the education sector and is in the final stage of developing the nationwide qualifications framework.

1. БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ БА МЭРГЭШЛИЙН ХҮРЭЭ

Дэлхийн олон улс боловсролын тогтолцоогоо нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэх ажлыг сүүлийн 30 гаруй жилд эрчимтэй хийж байна. Боловсролын шинэчлэлийн чиг хандлагыг авч үзвэл “*ори, үйл явцыг чухалчилсан тогтолцоо*”-ноос “*үр дүн, чадамжийг чухалчилсан тогтолцоо*”-нд шилжиж буй бөгөөд чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр/сургалт (competence based curriculum/training), хүрэх үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр/сургалт (outcome based curriculum/training), сүүлийн үед инженер, технологийн салбарынхныг хамарсан CDIO санаачлага (CDIO initiative) гээд санаа, зорилго ижилтэй санал, санаачлагыг өргөн цар хүрээтэй өрнүүлж байна.

1960-аад оны сүүл үед АНУ-д боловсролын салбар олон нийтийн шүүмжид өртөж, хямарч эхэлсэнээс улбаалан багш нарын мэдлэг, үр

чадварыг шүүх, үнэлэх оролдлогууд олонтаа хийгдэж байсан. Тэдгээр оролдлогын хүрээнд хүрэх үр дүнд суурилсан сургалтын асуудал зохих хэмжээнд хөндөгдөж байсан нь тухайн үеийн ажлын байрны судалгааны тайлангуудад тусгагдан үлдсэн байдаг (Young, 2009; Spreen, 2001).


Сургалтын хүрэх үр дүнг тодорхойлон, хэрэглэх санаачлага хамгийн анх мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтанд тусгалаа олж эхэлснийг 1984 оны 1 дүгээр сараас Шотландад өрнөсөн боловсролын шинэчлэлийн үйл явцаас харж болно. Тухайн үед, тус улсад залуучуудын ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, бүрэн дундаас дээшхи шатны боловсролд хамрагдалтын түвшин хэт доогуур болсон нь боловсролын шинэчлэлийн үндэс болсон ба Шотландын 16+ Action Plan, 1980-аад оны сүүл үеэс ИБУИВУ-ын хэмжээнд бий болгож эхэлсэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын мэргэшлийн хүрээ зэрэг нь тухайн үеийн боловсролын

шинэчлэлийн гол арга хэмжээнүүд байсан ба орчин цагийн мэргэшлийн тогтолцооны анхдагчид тооцогддог.

Үүнээс үзвэл, үндэсний боловсролын тогтолцооны шинэчлэлийн хүрээнд дотоод, гадаад чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, улмаар энэхүү тогтолцоог дэмжсэн мэргэшлийн хүрээг бий болгон, хэрэгжүүлэх нь үндсэндээ 1980-аад оноос хойш бий болсон олон улсын томоохон чиг хандлагын нэг юм. Анхны санаачлага Англи хэл бүхий өндөр хөгжилтэй оронд гарч, цааш нь мөн л Англи хэлтэй, өндөр хөгжилтэй орнуудад түгэн дэлгэрсэн байдаг. Гэхдээ, 1990-ээд оны сүүлээс албан ёсны Англи хэлгүй, хөгжиж буй орнууд ч мэргэшлийн хүрээг боловсруулан, хэрэгжүүлж эхэлсэн байдаг.

Өнөөгийн байдлаар дэлхийн 160 гаруй оронд ямар нэг төрлийн мэргэшлийн хүрээг боловсруулах, хэрэгжүүлэх эсвэл сонирхон судлах ажил хийгдэж байна.

Зураг 1. Мэргэшлийн хүрээ: Үүсэл, хөгжил



Эх үүсвэр: Судирман Яахьяа, Г.Цагаач (2016)

Хамрах цар хүрээний хувьд ялгаатай дараах гурван төрлийн мэргэшлийн хүрээг дэлхийн улс орнууд бий болгон, хэрэгжүүлж байна. Үүнд, салбарын мэргэшлийн хүрээ (мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн хүрээ, дээд боловсролын мэргэшлийн хүрээ гэх мэт.), үндэсний мэргэшлийн хүрээ, бүс нутгийн мэргэшлийн хүрээ (Европын мэргэшлийн хүрээ, Зүүн, Өмнөд Азийн холбоо (ASEAN)-ний мэргэшлийн хүрээ, Карибын мэргэшлийн хүрээ гэх мэт.).

Дээд боловсролын салбарын тухайд жишээлэн үзвэл, боловсролын тухай хуулинд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дээд боловсролын стандартууд болон мэргэшлийн зэрэг дэвийн нийцтэй байдлыг баталгаажуулах, олгож буй зэрэг дэвээ дэлхийн бусад орны дээд боловсролын сургалтын байгууллагаас олгож буй

боловсролын зэрэг дэвтэй дүйцэхүйц эсэхийг тогтоох зорилгоор Саудын Араб, Тайланд зэрэг нэлээд хэдэн улс дээд боловсролын салбартаа мэргэшлийн хүрээг боловсруулж, хэрэглэж байна.

Ер нь, боловсрол, сургалтын хөтөлбөрүүдийн уялдаа холбоо, уян хатан байдлыг нэмэгдүүлэх, өмнө нь эзэмшсэн боловсролын түвшинг тогтоон, хүлээн зөвшөөрөх ажлыг хөнгөвчилөх, насан туршийн боловсрол, сургалтыг дэмжих, мэргэшлийн хүрээний ил тод, нээлттэй байдлыг сайжруулах, багц цаг цуглуулах, шилжүүлэн тооцох боломжийг бүрдүүлэх, эсвэл чанарын баталгаажуулалтын тогтолцоог бий болгон, хөгжүүлэхийн алинд нь түлхүү ач холбогдол өгч байгаагаас үл хамааран улс орнуудын төр засаг мэргэшлийн хүрээг боловсролын шинэчлэлийн нэг чухал хэрэгсэл гэж үзэх хандлага улам нэмэгдэж байна.

2. МЭРГЭШЛИЙН ХҮРЭЭ, ТҮҮНИЙГ БИЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

2.1 Мэргэшлийн хүрээ ба мэргэшлийн тогтолцоо

Тухайн хүн тодорхой чиглэлд хүлээн зөвшөөрөгдсөн, чадамжтай гэдгээ нотлоход шаардлагатай мэдлэг, ур чадвар ба бусад онцлох шинжээр *мэргэшил* тодорхойлогдох ба ихэвчлэн диплом эсвэл гэрчилгээ хэлбэрээр илэрхийлэгддэг. Тодорхой ажил мэргэжилтэй холбоотой мэргэшлийн асуудлыг холбогдох мэргэжлийн холбоо, нийгэмлэг буюу салбарын зөвлөл эрхлэн, зохицуулж байдаг ч улс орны хувьд нэн чухал мэргэшлүүдийн асуудлыг төрөөс зохицуулах нь бий.

Мэргэшлийн хүрээ нь албан эсвэл албан бус боловсрол, эсвэл албан бус суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар ба бусад онцлох шинжээр тодорхойлогддог, чанарын баталгаа бүхий мэргэшлүүдийг логик уялдаатай, дараалан тогтоосон түвшнүүдийн дагуу ангилж, нэгдсэн тогтолцоонд оруулдаг арга хэрэгсэл юм (ОУХБ, 2007).

Мэргэшлийн хүрээ нь мэргэшлийн тогтолцооноос ялгаатай ойлголт. *Мэргэшлийн тогтолцоо* (qualifications system) нь мэргэшлийн талаар баримтлах бодлого, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, тухайлбал сургалтын байгууллагуудад сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох,

магадлан итгэмжлэх, мэргэшлийн үнэлгээ, баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлт хийх зэрэг сурах үйлийн үр дүнг төлөвлөх, тогтоох, хүлээн зөвшөөрч, баталгаажуулахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг багтаасан өргөн хүрээтэй ойлголт (ОУХБ, 2007). Үүнээс үзвэл, мэргэшлийн хүрээ нь мэргэшлийн тогтолцооны нэг л бүрэлдэхүүн хэсэг байна.

2.3 Мэргэшлийн хүрээг бий болгох хэрэгцээ, шаардлага

Улс орон бүр өөр өөр хэрэгцээ, шаардлагын улмаас мэргэшлийн хүрээг бий болгон, хэрэглэж байна. Олон орны хувьд иргэдийнх нь мэргэшсэн байдал ажлын байранд шаардагдаж буй мэдлэг, ур чадварт хүрэхгүй, тааруухан нийцэж байгаа нь мэргэшлийн хүрээг боловсруулан, хэрэгжүүлэх гол учир шалтгаан болсон байдаг. Ямайка, Тринидад-Тобаго, Гана, Өмнөд Африк зэрэг зарим орны тухайд чанар, нийцэл муутай сургалтын хөтөлбөрүүдээ сайжруулах шаардлага байсан. Харин, Англи зэрэг олон орны хувьд мэргэшлийн тогтолцооных нь уялдаа холбоогүй, нэгдмэл бус байдал гол шалтгаан нь болсон байдаг. Мөн, хүн амынх нь ихээхэн хэсэг албан боловсролд хамрагдаж чадахгүй байх, мөн сургууль завсардалтын түвшин өндөртэй улс орнуудын (Өмнөд Африк, Словен гэх мэт) тухайд иргэдийнхээ албан бус хэлбэрээр олж авсан мэдлэг, ур чадварыг нь үнэлэн, түвшинг нь тогтоож, албан боловсролын системтэй дүйцүүлэн, нэгтгэх нь үндсэн хэрэгцээ болсон тохиолдол ч бас цөөнгүй байна.

Харин, Монгол Улсын хувьд эдийн засгийн тогтворгүй байдал, ур чадвартай ажиллах хүчний эрэлт, хэрэгцээ, ажилгүйдэл, ядуурлын түвшин, үндэсний боловсрол, сургалтын үйл ажиллагаа, үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх хэрэгцээ, шаардлага, бүс нутгийн зарим нийгэмлэг, холбоон дахь улс орны гишүүнчлэл зэрэг олон учир шалтгааны улмаас үндэсний хэмжээний мэргэшлийн хүрээг бий болгон, хэрэгжилтийг нь хангах шаардлага байна.

АХБ-ны техник туслалцааны хүрээнд хэрэгжиж буй Дээд боловсролын шинэчлэлийн төслийн

дэд төсөл хэлбэрээр 2015-2016 онд хэрэгжсэн Дээд боловсролын шинэчлэлийн зөвлөх үйлчилгээ төслийн хүрээнд Монгол Улсад Үндэсний мэргэшлийн хүрээ (ҮМХ)-г бий болгох талаар зохих судалгаа хийгдэн, Монгол Улсын дээд боловсролын мэргэшлийн хүрээний загвар боловсруулагдаж, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулагдсан.¹ Мөн, ЕХ-ны техник туслалцаатай хэрэгжиж буй Монгол Улсын Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих төсөл (ТМБССДТ-1, EuropeAID/132815/C/SER/MN)-ийн хүрээнд ҮМХ-г бий болгон, загварчлах ажил 2015 оны 10 дугаар сард Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Сайдын хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн оролцоотой эхэлсэн нь эдүгээ дуусах шатандаа явж байна.

Судирман Яахяа, Г.Цагаач (2016) нарын хийсэн судалгаанаас үзвэл дэлхийн олон орны нэгэн адил Монгол Улс дараах хоёр үндсэн зорилгын улмаас ҮМХ-г бий болгож, хэрэгжилтийг нь хангах нь зүйтэй юм. Үүнд:

- (а) Чанарын баталгаатай, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, харилцан нийцтэй сургалтын стандартуудыг бий болгон, мөрдүүлэх;
- (б) Мэдлэг, чадвар эзэмшин, багц цаг цуглуулах суралцахуйн бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрөх.

Нэгтгэн авч үзвэл, мэргэшлийн хүрээ дараах боломжийг суралцагчид, төгсөгчид, тэдний эцэг эх, асран хамгаалагчид, ажил эрхлэгчид, ажил олгогчид, сургалтын байгууллагуудад олгоно. Үүнд:

- Мэргэшлүүдийн мөн чанар, мэргэшил хоорондын уялдаа холбоог тодорхой болгох замаар ил тод байдлыг хангах, сургалтын хүрсэн үр дүнг сургалтын тогтолцооны бүх хэсэг хооронд харьцуулах нөхцлийг бүрдүүлэх;
- Эзэмшүүлж буй мэргэшил хөдөлмөр эрхлэлт, суралцах хэрэгцээнд нийцэж буй эсэхийг; мөн суралцагч, эдийн засаг,

¹ Судирман Яахяа, Г.Цагаач (2016). Дээд боловсролын мэргэшлийн хүрээ (санал), Үндэсний мэргэшлийн хүрээ, кредит системийн зөвлөх баг, Дээд боловсролын шинэчлэлийн зөвлөх үйлчилгээ, Дээд боловсролын шинэчлэлийн төсөл (HERP MON Loan No. 2766), Монгол Улс

Судирман Яахяа, Г.Цагаач (2016). Үндэсний мэргэшлийн хүрээг бий болгож, хэрэгжүүлэх нь (зөвлөмж), Үндэсний мэргэшлийн хүрээ, кредит системийн зөвлөх баг, Дээд боловсролын шинэчлэлийн зөвлөх үйлчилгээ, Дээд боловсролын шинэчлэлийн төсөл (HERP MON Loan No. 2766), Монгол Улс

боловсрол, сургалтын байгууллагуудын хэрэгцээнд нийцэж буй эсэхийг баталгаажуулах;

- Насанд хүрэгчдийн ур чадварыг тасралтгүй сайжруулах гэх мэт насан туршийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх;
- Үнэлгээ, баталгаажуулалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, уян хатан, бие даан суралцах гэх мэт үйл ажиллагааг дэмжих;
- Багц цаг цуглуулах, шилжүүлэх, дүйцүүлж тооцох тогтолцоог бүрдүүлэх;
- Мэдлэг, чадвар, дадлын олон улсад харьцуулагдахуйц, чанарын баталгаажуулалт бүхий стандартуудад суурилсан мэргэшлүүдийн хөгжлийг хөхиүлэн дэмжих замаар боловсрол, сургалтын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх;
- Бүх хэлбэрийн сурах үйл ажиллагаа болон түүгээр хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрч, баталгаажуулах нөхцлийг бүрдүүлэх замаар хувь хүний хөдөлмөр эрхлэх, суралцах боломжийг нэмэгдүүлэх;
- Эрэлтэд суурилсан боловсрол, сургалтын тогтолцооны шинэчлэлийн тасралтгүй, тогтвортой байдлыг дэмжих.

3. ҮМХ-НИЙ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

3.1 Tracked, Linked, Unified мэргэшлийн хүрээ

Бүтэц талаасаа ҮМХ нь мэргэжлийн боловсрол болон ерөнхий боловсролын мэргэшлүүдийг тус тусад нь бүлэглэж заагласан буюу *tracked*, тус тусад нь бүлэглэж заагласан мэргэшлүүдтэй ч адил төстэй, нийтлэг талд нь тулгуурлан өөр хооронд нь багц цаг шилжүүлэх, дүйцүүлэн тооцох боломжтой буюу *linked*, тусдаа зааглагдсан мэргэшлүүдгүй, нэгдмэл мэргэшлийн хүрээ буюу *unified* гэж ангилагддаг (Howieson, C., Raffe, D.1999).

Өнгөрсөн үед, олон орон *tracked* хэлбэрийн мэргэшлийн хүрээг бий болгосон байдаг ба энэ нь боловсролын дэд салбаруудынх нь бие даасан байдал, өөр хоорондынх нь уялдаа тааруу байж ирсэнтэй холбоотой. Гэхдээ, боловсролын салбарынх нь өргөжилт, мэргэшил эзэмших боломж, хэлбэр өргөжин тэлсээр байгаагаас мэргэшлийн хүрээгээ илүү нэгдмэл эсвэл холимог

хэлбэр лүү шилжүүлэх болсон. Австрали *linked* хэлбэрийн, Шотландын ерөнхий болон мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлүүд *unified*, харин тэдгээр нь дээд боловсролын мэргэшлүүдтэй *linked* хэлбэрээр холбогддог гэдэг утгаараа холимог хэлбэрийн мэргэшлийн хүрээний жишээнд ордог (Ron Tuck, 2007).

Ямар хэлбэрийн мэргэшлийн хүрээ байх вэ гэдэг нь зорилгоос нь хамаарна. Хэрэв, бүх төрлийн мэргэшлийг хүрэх үр дүнд суурилсан хэлбэрт оруулна гэх мэт нийтлэг зорилгыг хангахыг эрмэлзэж буй бол *unified* хэлбэрийн мэргэшлийн хүрээг бий болгох хэрэгтэй болно. Хэрэв, өөр өөр мэргэшлийн бүлэг хооронд багц цаг шилжүүлэлт, дүйцүүлэлт хийх нөхцлийг бүрдүүлэн замаар суралцагчдад дэвшин суралцах боломж олгох зорилготой бол *linked* хэлбэрийн мэргэшлийн хүрээг бий болгох нь илүү зохимжтой.

Монгол Улсын хувьд *linked* хэлбэрийн мэргэшлийн хүрээг илүү зохимжтой хэмээн судлаачийн хувьд үзэж байна. Ийм хэлбэрийн мэргэшлийн хүрээг бий болгосноор суралцагч, мэргэшлээ дээшлүүлэхийг хүсч буй ажил эрхлэгчид дан ганц тухайн мэргэшлийн бүлэг дотор ахиж дэвших боломжоор хангагдаад зогсохгүй, мэргэшлийн бүлэг хооронд дэвшин суралцах боломжоор хангагдах юм.

3.2 Хатуу ба сул мэргэшлийн хүрээ

Дараагийн нэг тодорхой болгох асуудал нь мэргэшлийн хүрээ нь стандарт байдлаар нийтэд дагаж мөрдөгдөх, “хатуу” зохицуулалтын арга хэрэгсэл болдог хүрээ байх уу (Тайланд, Индонезийнх шиг), эсвэл харьцангуй “сул”, сайн дурын үндсэн дээр мөрдөгдөх, нэлээд уян хатан шинжтэй хүрээ байх уу (Австрали, Шотландынх шиг) гэдэг асуудал. Энэ асуудал мөн л зорилгоос нь хамаарна.

Бусад улсын туршлагаас үзвэл, ҮМХ нь боловсролын дэд салбаруудын ялгааг тод харуулахуйц байх үед практик үнэ цэнэтэйд тооцогддог ба үүнийг нэг бол нэгдмэл (*unified*) бөгөөд сул хэлбэрийн, эсвэл холбоостой (*linked*) бөгөөд хатуу хэлбэрийн мэргэшлийн хүрээг бий болгох замаар хангадаг (ОУХБ, 2010).

Нэгдмэл (*unified*) бөгөөд сул хэлбэрийн мэргэшлийн хүрээг засаглалын хувьд нэг л байгууллага хариуцан ажиллах

боломжтой бол холбоостой (linked) бөгөөд хатуу хэлбэрийн мэргэшлийн хүрээн дэх боловсролын дэд салбар бүрийг тус тусад нь хариуцсан байгууллага байхын зэрэгцээ бүхэлд нь удирдлага, зохицуулалтаар хангах, боловсролын нийт салбарт үйлчилэх нийтлэг зарчмуудыг бий болгон, багц цаг дүйцүүлэх, шилжүүлэн тооцох асуудлыг зохицуулах чиг үүрэгтэй үндэсний зөвлөл буюу хороо байх хэрэгтэй болно.

3.3 Мэргэшлийн хүрээний үндсэн бүрдэл хэсгүүд

Мэргэшлийн түвшингүүд болон түвшний ерөнхий тодорхойлогчид нь мэргэшлийн хүрээний үндсэн бүрдэл хэсгүүд юм. Суралцагч боловсролын шат ахин суралцахын хэрээр өсөн нэмэгдэх оюуных нь эрэлт хэрэгцээ болон суралцахуйн хүндрэлийн түвшинг мэргэшлийн хүрээний түвшингүүд илтгэдэг. Мэргэшлийн түвшин бүрээр суралцахуйн хэв шинж буюу суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, бусад онцлох

шинжийг нарийвчилан тодорхойлно.


Дэлхийн улсууд ҮМХ-гээ 8-12 түвшинтэй боловсруулсан байдаг ба хэдэн түвшинтэй байх нь уг хүрээ нь тухайн улсын хүн амд нийтэд нь хамааралтай байх уу (inclusive framework), эсвэл хүн амын зарим бүлэгт хамааралгүй байх (exclusive framework) уу гэдгээс хамаардаг. Зарим улсын хувьд нийт хүн амд нь хамааралтай байх боловч дээд боловсролын мэргэшлүүд нь 4-өөс олон түвшинтэй байх тул 12 хүртэл түвшинтэй байдаг. Монгол Улсын хувьд дээд боловсролын мэргэшлүүд нь 4 түвшинд хуваагдах тул, нөгөөтэйгүүр мэргэшлийн хүрээ нь Монгол Улсын нийт иргэдэд² хамааралтай байна гэж үзвэл 10 түвшинтэй мэргэшлийн хүрээ загварчлагдах нь зүйтэй гэж үзэж байна.

Энэ чиглэлээрх анхдагчдын нэг болох Шотландын 12 түвшин бүхий ҮМХ-г доор харуулав.

Хүснэгт 1. Шотландын кредит ба мэргэшлийн хүрээ

THE SCOTTISH CREDIT AND QUALIFICATIONS FRAMEWORK

This Framework diagram has been produced to show the mainstream Scottish qualifications already credit rated by SQA and HEIs. However, there are a diverse number of learning programmes on the Framework, which, due to the limitations of this format, cannot be represented here. For more information, please visit the SCQF website at www.scqf.org.uk to view the interactive version of the Framework or search the Database.



SCQF Levels	SQA Qualifications		Qualifications of Higher Education Institutions	Apprenticeships & SVQs
12			Doctoral Degree	Professional Apprenticeship
11			Masters Degree, Integrated Masters Degree, Post Graduate Diploma, Post Graduate Certificate	Graduate Apprenticeship Professional Apprenticeship SVQ
10			Honours Degree, Graduate Diploma, Graduate Certificate	Graduate Apprenticeship Professional Apprenticeship
9		Professional Development Award	Bachelors / Ordinary Degree, Graduate Diploma, Graduate Certificate	Graduate Apprenticeship Technical Apprenticeship SVQ
8		Higher National Diploma	Diploma Of Higher Education	Higher Apprenticeship Technical Apprenticeship SVQ
7	Advanced Higher, Awards, Scottish Baccalaureate	Higher National Certificate	Certificate Of Higher Education	Modern Apprenticeship SVQ
6	Higher, Awards, Skills for Work Higher			Modern Apprenticeship Foundation Apprenticeship SVQ
5	National 5, Awards, Skills for Work National 5			Modern Apprenticeship SVQ
4	National 4, Awards, Skills for Work National 4	National Certificate	National Progression Award	SVQ
3	National 3, Awards, Skills for Work National 3			
2	National 2, Awards			
1	National 1, Awards			

Эх үүсвэр: www.scqf.org.uk

² Сургуулийн өмнөх боловсролыг ҮМХ-нд оруулахгүй байх нь түгээмэл бөгөөд энэ нь сургуулийн өмнөх боловсролын тогтолцооны хүрээнд мэргэшил олгодоггүй гэж олонх тохиолдолд үздэгтэй холбоотой (ОУХБ, 2007). Гэхдээ, сургуулийн өмнөх боловсролын тогтолцооны хүрээнд хүүхдүүдийн эзэмшсэн мэдлэг, ур чадварыг үнэлэх асуудлыг орхигдуулж болохгүй юм

Суралцахуйн үр дүнгийн хэв шинжийн хувьд мэдлэг, ур чадвар ба бусад онцлох шинжийг сонгон, түвшинг тодорхойлогчдыг тодорхойлох нь зүйтэй (ТМБССДТ-1 төсөл, 2018) гэж үзэж байна. Шалгуур үзүүлэлтүүдийн хувьд мэдлэгийг гүн гүнзгий байдал, цар хүрээ, төрөл, төвөгшил (хүндрэл)-ийнх нь зэргийг харгалзан; ур чадварыг төрөл, төвөгшил (хүндрэл)-ийнх нь үүднээс; харин бусад онцлох шинжийн хувьд аливаа зүйлийг амжилттай хийх чадвар ба үр ашигтай хийх

чадвар талаас нь тодорхойлно гэж дээрх судалгаануудад үзэж байна.

Улмаар, ҮМХ-ний хэв шинж, түвшний ерөнхий тодорхойлогчид нь нягтлан бодох бүртгэл, математик гэх мэтчилэн мэргэжлийн чиглэл бүрээр тусгайлсан тодорхойлогчдыг боловсруулахад хэрэглэгддэг. Зохих ойлголтыг өгөх үүднээс Индонезийн ҮМХ-ний дээд боловсролын мэргэшлүүдийн түвшнийг ерөнхий тодорхойлогчдыг доор харуулав.

Хүснэгт 2. Индонезийн дээд боловсролын мэргэшлүүдийн түвшинг тодорхойлогчид

ЧАДАМЖИЙН ХЭМЖЭЭС	БАКАЛАВР (S1)	МАГИСТР (S2)	ДОКТОР (S3)
ШИНЖЛЭХ УХААНЫ	Шинжлэх ухааны мэдлэг, чадвараа нийгэмд чиглэсэн бүтээлч үйл ажиллагаанд хэрэглэх чадвартай	Судалгаа - хөгжүүлэлтээр дамжуулан нийгэмд чиглэсэн бүтээлч үйл ажиллагааг сайжруулах чадвартай	Судалгаагаар дамжуулан шинжлэх ухааны тодорхой чиглэлд шинэ онол, ойлголтыг бий болгох чадвартай
СУДАЛГААНЫ	Судалгаагаар дамжуулан шинжлэх ухааны хөгжил, үйл явцыг ойлгох чадвартай	Судалгаагаар дамжуулан шинжлэх ухааныг хөгжүүлэх үйл явцад оролцох чадвартай	Судалгаагаар дамжуулан шинжлэх ухааныг хөгжүүлэх үйл явцыг манлайлах, удирдах чадвартай
ТАНИН МЭДЭХҮЙН	Мэргэшсэн чиглэлд нь бий болсон асуудлыг танин мэдэх, таамаглах чадвартай	Мэргэшсэн чиглэлд нь бий болсон асуудлыг шийдвэрлэх чадвартай	Салбар дамнасан хандлагаар асуудлыг шийдвэрлэх чадвартай
НӨЛӨӨЛӨХ	Тухайн нөхцөлд түргэн дасан зохицох чадвартай (шинийг санаачлагч)	Нөхцөл байдлаас үл хамааран бие даан ажиллах чадвартай (бүтээлч)	Өөрийн онол, үзэл баримтлалд тулгуурлан тухайн нөхцөл байдлыг өөрчлөх чадвартай. (оюунлаг)

Эх үүсвэр: Судирман Яахья, Г.Цагаач (2016)

Монгол Улс анх удаа мэргэшлийн хүрээг бүрдүүлэн, хэрэгжилтийг нь хангах гэж буй хэрэг биш юм. Мянганы сорилтын сангийн төслийн хүрээнд Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын мэргэшлийн 6 түвшинтэй хүрээг Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн даргын 2011 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 1 тоот тушаалаар баталгаажуулан, хэрэгжилтийг нь хангаж ирсэн туршлага Монгол Улсад бий. Энэ ажлын хүрээнд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын үйл ажиллагаанд чадамжид суурилсан сургалтын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг амжилттай

хийж ирсэн бөгөөд одоогийн байдлаар уул уурхай, зам тээвэр, барилга, хөдөө аж ахуй гэсэн эдийн засгийн 8 салбарын 70 гаруй сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө чадамжид суурилсан стандартуудад нийцсэн байдлаар боловсруулагдаад байна (www.mol.gov.mn).

Үндсэндээ, үндэсний хэмжээний буюу нэгдсэн мэргэшлийн тогтолцоо Монгол Улсад өнгөрсөн хугацаанд байгаагүй ба АХБ, ДБ зэрэг хандивлагч бусад байгууллагууд Монгол Улсын Засгийн Газарт ҮМХ-г ойрын хугацаанд бий болгон, хэрэгжүүлэх тухай зөвлөмжийг өнгөрсөн хугацаанд өгч байсан (Хайрцаг 1) байдаг.

Хайрцаг 1. Монгол Улсад ҮМХ-г бий болгох тухай зөвлөмж

Төвлөрсөн шалгалт, үнэлгээ, баталгаажуулалт бүхий мэргэшлийн хүрээг ойрын ирээдүйд бий болгоход тэргүүлэх ач холбогдол өгөх хэрэгтэй. Ийм хүрээ нь ТМБС-ын үр дүнгийн нийцтэй байдлыг баталгаажуулах ач холбогдолтой. Шалгалт, үнэлгээ, баталгаажуулалт бүхий мэргэшлийн төвлөрсөн тогтолцоо, хүрээг бий болгоход үйлдвэр, аж ахуйн байгууллагуудаас практик туршлагатай хүмүүсийг оролцуулах нь нэн чухал. Эрэлтээр-удирдуулж, чадамжид суурилан сайтар боловсруулагдсан сургалтын хөтөлбөрийн загвар болон үйлдвэр, аж ахуйн байгууллагуудын төлөөллийг ханган боловсруулагдсан шалгалт, үнэлгээ, баталгаажуулалттай мэргэшлийн тогтолцоо, мэргэшлийн хүрээ нь чанарын баталгаажуулалтын бат бэх суурь болно. Мөн ТМБС-ын үр дүнгийн чанарын баталгаажилт болно. Урт хугацаанд, Австрали, Шинэ Зеланд, Их Британи, Өмнөд Африк зэрэг улсуудын ҮМХ-тэй ойролцоо мэргэшлийн хүрээг бий болгох хэрэгтэй.

Эх үүсвэр: Дэлхийн Банк (2010)

4. ДҮГНЭЛТ

Улам бүр өсөн нэмэгдэж буй бараа, үйлчилгээний чөлөөт худалдаа; капитал, технологи, ур чадварын чөлөөт хөдөлгөөн; тээвэр, харилцаа холбооны технологийн өндөр өсөлт бүхий глобал эдийн засгийн орчинд мэргэшлийн хүрээг боловсруулж, хэрэгжилтийг хангах нь дэлхийн улс орнуудын хувьд нэн чухал шаардлага болсон билээ.

Энэ өгүүлэлд мэргэшлийн хүрээ гэж юу болох, түүний үүсэл хөгжил, үндсэн бүрдэл хэсгүүд болон Монгол Улсад энэ хүрээг бий болгох ажлын явц, үр дүнгийн талаар товч танилцуулав. ҮМХ бүхий бусад улсын туршлагаас үзвэл түүний амжилттай хэрэгжилт нь сонирхогч талуудын оролцоо, харилцан ойлголцол, зөвшилцөлөөс ихээхэн хамаарч байна. Хэрэгжилтийнх нь эхний шатанд төр, засгийн дэмжлэг нэн чухал бөгөөд дунджаар 3-5 жилийг шаардах эхний шатны хэрэгжилтийн үед холбогдох талуудын чадавхийг бүрдүүлж, бэхжүүлэх үйл ажиллагааг өргөн цар хүрээтэй хэрэгжүүлэх хэрэгтэй.

Монгол Улсын мэргэжлийн боловсрол,

сургалтын салбарт 2011 оноос мэргэшлийн хүрээний үндэс суурь тавигдсан, сургалтын хөтөлбөрүүд нь чадамжид суурилсан байдлаар боловсруулагдаж, хэрэгжээд багагүй хугацаа өнгөрсөн тул, мөн ерөнхий боловсролын салбарт өнгөрсөн хугацаанд өрнөсөн чанарын шинэчлэлийн хүрээнд сургалтын цөм хөтөлбөрүүдийг үр дүнд суурилсан байдлаар боловсруулан, хэрэгжүүлэх ажил зохих хэмжээнд хийгдэж ирсэн тул Монгол Улс нийтлэг мөрдөгдөх ҮМХ-тэй боллоо гэж үзэхэд, боловсрол, сургалтын бусад дэд салбарынхны хүрсэн үр дүнд хүрэхийн тулд дээд боловсролын салбарынхан илүү их хүчин чармайлт гаргах хэрэгтэй болж байна.

Учир нь хүрэх үр дүн, чадамжид суурилсан сургалт нь дээд боловсролын салбарт харьцангуй шинэ ухагдахуун бөгөөд чанарын баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэн, сайжруулах замаар дээд боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд мэргэшлийн хүрээг бий болгож, хэрэгжилтийг нь хангах шаардлагатай байна. Дээд боловсролын салбарт энэ ажлыг зарим улсын жишгээр зарим нэг мэргэшлийг сонгон турших байдлаар эхлүүлж болно. Жишээ нь Индонези гэхэд сувилахуй, нягтлан бодох бүртгэл, аялал жуулчлал гэсэн гурван салбарыг улсын хэмжээн дэх ач холбогдлын түвшин, хэрэгжүүлэх боломж, нөлөө, төлөөлөх чадвар гэсэн 4 шалгуураар сонгон, мэргэшлийн үндэсний хүрээнийхээ хэрэгжихүйц байдлыг туршсан байдаг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Andrea Bateman & Mike Coles (2013). Qualifications Frameworks and Quality Assurance of Education and Training, WB

Australian Qualifications Framework Council (2013). Australian Qualifications Framework, 2nd Ed. January 2013

Билл Фэйрбэйрн, Г.Цагаач (2018). *Монгол Улсын Үндэсний мэргэшлийн хүрээ: Үзэл баримтлал*, Монгол Улсын Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих төсөл (ТМБССДТ-1, EuropeAID/132815/C/SER/MN)

Судирман Яахяа, Г.Цагаач (2016). *Дээд боловсролын мэргэшлийн хүрээ (санал)*, Үндэсний мэргэшлийн хүрээ, кредит системийн зөвлөх баг, Дээд боловсролын

шинэчлэлийн зөвлөх үйлчилгээ, Дээд боловсролын шинэчлэлийн төсөл (HERP MON Loan No. 2766), Монгол Улс

Судирман Яахьяа, Г.Цагаач (2016). *Үндэсний мэргэшлийн хүрээг бий болгож, хэрэгжүүлэх нь (зөвлөмж)*, Үндэсний мэргэшлийн хүрээ, кредит системийн зөвлөх баг, Дээд боловсролын шинэчлэлийн зөвлөх үйлчилгээ, Дээд боловсролын шинэчлэлийн төсөл (HERP MON Loan No. 2766), Монгол Улс

Directorate General of Higher Education (2011). Indonesian Qualification Framework and Direction for Educational Institute Curriculum, Ministry of Education and Culture, Indonesia

ILO (2009). Learning from the first qualifications frameworks, Geneva

ILO (2010). The implementation and impact of National Qualifications Frameworks: Report of a study in 16 countries, Geneva

Ron Tuck (2007). An Introductory Guide National Qualifications Frameworks: Conceptual and Practical Issues for Policy Makers, ILO

www.scqf.org.uk

UNESCO (2014). Global Inventory of Regional and National Qualifications Frameworks, Volume II: National and Regional Cases